


Ректорын 2015 оны 10 сарын 09-ны
өдрийн тоот тушаалын хавсралт



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬД ГАДААДЫНИРГЭНИЙГ СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ (төсөл)

1. Нийтлэг үндэслэл

1.1 Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийн боловсролын зэрэг олгох хөтөлбөр, оюутан солилцооны хөтөлбөрт /боловсролын зэрэг олгохгүй/ гадаадын иргэдийг суралцуулахад Монгол улсын 2010 оны Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам", БСШУ-ын сайдын 2001/113 тоот тушаалаар баталсан "Монгол улсын дээд боловсролын байгууллагад гадаадын иргэдийг суралцуулах журам" болон энэхүү журмыг баримтална.

1.2 ШУТИС-д суралцах гадаадын иргэн болон ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.3 Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн элсэлтийг хичээлийн жилд 1 удаа, магистр, докторын зэрэг олгох хөтөлбөр болон оюутан солилцооны хөтөлбөрийн элсэлтийг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулна.

2. Гадаадын иргэнд тавигдах шаардлага

2.1 Монгол улсад мөрдөгдөж буй боловсролын агуулга, түвшин, стандартад нийцсэн, түүнтэй дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн, амжилттай суралцан төгссөн, хууль зүйн хувьд өөрийгөө хариуцах бүрэн чадамжтай гадаадын иргэн байна. Боловсролын түвшинг илтгэх диплом, гэрчилгээ нь тухайн улсын боловсролын байгууллагад бүртгэлтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байна. Бакалаврын хөтөлбөрт суралцах гадаадын иргэн элсэлтийн ерөнхий шалгалт эсвэл түүнтэй дүйцэхүйц шалгалтыг өгсөн байна.

2.2 Гадаадын иргэн нь боловсролын зэрэг олгох хөтөлбөрүүдэд Монгол хэлээр суралцах бол Монгол хэлийг шаардлага хангасан түвшинд эзэмшсэн байх ба түүнийг нотлох бичиг баримтын баталгаажуулсан хуулбарыг элсэх хүсэлтийн хамт ирүүлнэ. Монгол хэлний мэдлэгийн түвшинг нотлох бичиг баримт байхгүй буюу мэдлэгийн түвшин хангалтгүй бол эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлтэй Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хамрагдан, шаардлага хангасан тохиолдолд суралцах хүсэлт гаргаж болно.

2.3 Англи хэл дээр сургалт нь явагддаг боловсролын зэрэг олгох хөтөлбөрт элсэх, оюутан солилцоогоор суралцах гадаадын иргэнд тухайн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн англи хэлний мэдлэг чадвартай байхыг шаардана. Англи хэлний олон улсын түвшний шалгалтыг /TOEFL, IELTS/ өгсөн бол шалгалтын оноо бүхий гэрчилгээг хавсарган ирүүлнэ.

Ректорын 2015 оны 10 сарын 09-ны
өдрийн / тоот тушаалын хавсралт



2.4 Гадаадын иргэн элсэн суралцахаар хүсэлт гаргаж буй сургалт, хөтөлбөрийг хариуцсан бүрэлдэхүүн сургууль, институт, салбар, мэргэжлийн тэнхимээс мэргэжлийн болон дипломын голч дүнд тавигдсан шаардлагыг хангана.

3. Элсэн, суралцах хүсэлт гаргах

3.1 ШУТИС-д суралцахаар хүсэлт гаргаж буй гадаадын иргэн нь хөтөлбөр хариуцсан бүрэлдэхүүн сургуулийн удирдлагад хандан хүсэлт гаргана.


3.2 Элсэн суралцах тухай хүсэлтийг дараах хугацаанд багтаанирүүлсэн байна.

3.2.1 Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт элсэх өргөдөл, хүсэлтийг жил бүрийн 5 сард багтаан ирүүлнэ. ШУТИС-иас гадаад иргэдийн материалыг жил бүрийн 6 дугаар сард багтаан БСШУЯ-нд хүргүүлнэ.

3.2.2 Магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрт намрын улиралд суралцах бол 3 дугаар сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны хооронд, хаврын улиралд суралцах бол 9 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 01-ний хооронд элсэх хүсэлт, өргөдөл, холбогдох бусад материалыг ирүүлнэ.

3.3 Суралцах хүсэлт гаргаж буй гадаадын иргэн дээр дурьдсан хугацаанд Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, баталгаат /цахим/ шуудангаар суралцах бүрэлдэхүүн сургуулийн удирдлагад дараах материалыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:

- Хувийн өргөдөл
- Товч намтар
- Элсэлтийн анкет / ШУТИС-ийн вебсайтаас татаж бөглөх /
- Бүх шатны боловсролын бичиг баримтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /Монгол эсвэл англи хэлнээс өөр хэлээр бичигдсэн бол эдгээр хэлний аль нэг рүү баталгаажсан орчуулга хийлгэсэн байх/
- Гадаад паспортын хуулбар
- Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгө, санхүүгийн баталгаа /өргөдөл гаргагчийн эсвэл асран хамгаалагчийн банкны тодорхойлолт болон түүнтэй дүйцэх баталгаа/
- Тухайн иргэнийг Монгол улсад суралцуулахаар илгээж буй байгууллагын болон профессорын тодорхойлолт
- Хэлний чадвар, түвшинг тодорхойлох гэрчилгээ, сертификат
- Эрүүл мэндийн үзлэгээр орсон бичиг баримт/сүүлийн 3 сард эмнэлгээс олгосон байх/
- Цээж зураг /сүүлийн 6 сард авахуулсан, 3Х4 хэмжээтэй байх/



3.4 Гадаадын иргэний ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн удирдлага суралцуулах боломжтой хөтөлбөрийн санал болон зөвшөөрлийг холбогдох асуудал, сургалт хариуцсан нэгжид ирүүлнэ.

4. Элсэх хүсэлтийг шийдвэрлэх ба гэрээ байгуулах

4.1 Бүрэлдэхүүн сургуулийн удирдлага, хөтөлбөр, сургалт хариуцсан нэгжийн удирдлагань гадаадын иргэний суралцах тухай хүсэлт, холбогдох материалыг хоёр долоо хоногийн дотор хянан, суралцуулахтай холбоотой саналаа Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албанд (ГХХАА) бичгээр ирүүлнэ.

4.2 Бүрэлдэхүүн сургууль, холбогдох нэгжийн удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн ГХХАА шаардлага хангасан гадаадын иргэнийг суралцуулах зөвшөөрөл хүссэн албан бичгийг БСШУЯ-нд хүргүүлнэ. БСШУЯ-наас суралцах эрх олгосон гадаадын иргэнд ГХХАА виз болон оршин суух зөвшөөрлийг авах талаар холбогдох мэдээлэл зөвлөлгөө өгч, гадаадын иргэний суралцах боломжийг бүрдүүлнэ.

4.3 Гадаадын иргэн нь өөрийн суралцах бүрэлдэхүүн сургуулийн захиралтай гэрээ байгуулна. БСШУ-ны сайдын 2001 оны 113 тоот тушаалаар баталсан Монгол улсын дээд боловсролын байгууллагад гадаадын иргэдийг суралцуулах журмын холбогдох заалт, нөхцөлийг гэрээнд тусгана.

4.4 Гадаадын иргэнийг БСШУЯ-ны албан тоот, бусад холбогдох байгууллагын албан бичиг, зөвшөөрөлд үндэслэн ШУТИС-ийн Ректорын тушаалаар тухайн хөтөлбөрт элсүүлэн суралцуулна.


4.5 ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталгаажсан, суралцах эрх авсан гадаадын иргэн хичээл эхлэхийн өмнөх долоо хоногт өөрийн биеэр ирж бүртгүүлэн, хичээл сонголтоо хийн, суралцах болон оюутны бусад үйлчилгээг авах боломжтой.

5. Суралцах үйл ажиллагааг зохицуулах

5.1 ШУТИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн өөрийн амь нас, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалыг өөрөө хариуцан хийлгэсэн байна.

5.2 Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, салбар, тэнхим нь гадаад оюутанд сургалтын үйл ажиллагаатай холбоотой заавар зөвлөлгөө өгч, дэмжиж ажиллана.

5.3 Гадаадын иргэн Монгол улсад орж ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт (ИХШХЕГ) шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлж, тус улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрөл авч, буцах үед бүртгэлээс хасуулна.



5.4 ИХШХЕГ нь гадаадын иргэнд Монгол улсад оршин суух зөвшөөрлийг 2 жил хүртэл хугацаагаар олгохболон сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Оршин суух зөвшөөрлийн хугацааг суралцаж буй бүрэлдэхүүн сургууль, институтын тодорхойлолт, сурлагын байдал, гэрээний биелэлт, холбогдох бичиг баримтыг үндэслэн сунгана.

5.5 Гадаад оюутан нь өвөл, зуны улирлын амралтаар, судалгааны ажлаа өөрийн улс орондоо хийх болон бусад ажлаар нутагтаа буцах тохиолдолд хүсэлтээ холбогдох бүрэлдэхүүн сургууль, институтэд гаргаж, ГХХАА-р дамжуулан ИХШХЕГ-аас гарах-орх визний зөвшөөрөл авна.

5.6 Холбогдох бүрэлдэхүүн сургууль, институт хуульд заасан хугацаанд гадаадын иргэнийг бүртгүүлж, виз болон оршин суух зөвшөөрөл авах ажлыг хариуцан, буцах үед бүртгэлээс хасуулна.

5.7 Гадаад оюутан нь оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө өөрийн биеэр ГХХАА-нд шаардагдах материалыг бүрдүүлэн зөвшөөрлийн хугацаагаа сунгуулна. Хуульд заасан хугацаанд сунгуулаагүй тохиолдолд холбогдох хариуцлагыг оюутан өөрөө хариуцна.

5.8 Гадаад оюутан нь өвчтэй буюу бусад хүндэтгэх шалтгааны улмаас тодорхой хугацаанд хичээлд суух боломжгүй болсон тохиолдолд холбогдох салбар, тэнхим, сургалтын албандаа мэдэгдэнэ.

6. Бусад

6.1 ШУТИС-д өмнө нь суралцах явцдаа Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дотоод дүрэм, журмыг зөрчиж сургуулиас хасагдсан гадаадын иргэн дахин суралцах боломжгүй.

6.2 Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд ШУТИС-д элсүүлэхгүй баэлссэн тохиолдолд суралцах эрхийг цуцална.

6.3 ШУТИС-д суралцаж буй гадаадын иргэн нь Монгол улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох хууль тогтоомж, ШУТИС-н дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөж, Монгол улсын түүх соёл, ёс заншилд хүндэтгэлтэй хандана.

6.4 Гадаадын иргэн нь ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг зохицуулдаг холбогдох дүрэм, журмыг дагаж мөрдөнө.